



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БОР-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 06 сарын 27 өдөр

Дугаар A/122

Бор-Өндөр сум

Шуурхай штаб байгуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэхь хэсэг, Төсвийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3, 32.1.8, 32.1.12 дахь, Засгийн газрын 2015 оны 286 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Үерийн болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангуулах, хариу арга хэмжээг шуурхай зохионы байгуулах үүрэг бүхий Шуурхай штабыг 2024 оны 06 дугаар сарын 26-ны өдрөөс байгуулсугай.
2. Шуурхай штабын ажиллах журмыг нэгдүгээр, бүрэлдэхүүнийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
3. Үүссэн нөхцөл байдлын хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулж, шуурхай штабт дэмжлэг үзүүлэх, мэргэжлийн удирдлагаар хангаж ажиллахыг Онцгой байдлын хэлтсийн дарга (дэд хурандаа Г.Мөнхнаран)-д үүрэг болгосугай.
4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг даргын орлогч (Х.Галбадрах)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.АДЪЯАБИЛЭГТ



Шуурхай штабын бүрэлдэхүүн

Шуурхай штабын дарга:

Бор-Өндөр сумын орлогч, дарга

Х.Галбадрах

Нарийн бичгийн дарга:

**Ангилалын сургалт сурталчилгаа
урьдчилан сэргийлэх асуудал
хариуцсан мэргэжилтэн дэслэгч**

Ч.Болорчимэг

Гишүүд:

Засаг даргын тамгын газрын дарга

3.Ууганжаргал

Байгаль хамгаалагч

Б.Баярбаясгалан

**Бор-Өндөр сумын Нэгдсэн
эмнэлгийн дарга**

А.Батбаатар

**“Бор-Өндөр” Уулын баяжуулах
үйлдвэрийн захирал**

Б.Магсаржав

**Бор-Өндөр сумын сум дундын
Цагдаагийн хэлтсийн дарга
Цагдаагийн дэд хурандаа**

Т.Энхбаяр


3 дугаар багийн Засаг дарга

С.Байгальмаа

4 дүгээр багийн Засаг дарга

Ч.Саруулмөнх

ШУУРХАЙ ШТАБЫН АЖИЛЛАХ ЖУРАМ



Нэг. Зорилго

1.1. Шуурхай штаб (цаашид "штаб" гэх) нь гамшиг, ослын үед нөхцөл байдлыг үнэлж хариу арга хэмжээг шуурхай хэрэгжүүлэх, холбогдох байгууллагуудын харилцан ажиллагааг зохион байгуулах, удирдлага зохицуулалтаар хангах, тулгамдсан асуудлыг шийдвэрлэх чиг үүрэгтэй ажиллана.

Хоёр. Штабын бүтэц, зохион байгуулалт

2.1. Штабын өдөр тутмын үйл ажиллагааг ажлын хэсгийн дарга, нарийн бичгийн дарга нар удирдан зохион байгуулж, нэгдсэн шуурхай штабын дарга хяналт тавина.

2.2. Штаб нь гамшиг, аюулт үзэгдэл, томоохон хэмжээний ослын нөхцөл байдалтай уялдуулан гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, сумдын шуурхай штабын үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлнэ.

2.3. Штаб нь ажлын хэсгийн ахлагч, нарийн бичгийн дарга, гишүүд, төлөвлөлт, ажиллагаа, нөөц хангалт, захиргаа- санхүүгийн баг, хэвлэл мэдээллийн хэсгээс бүрдэнэ.

2.4. Штабын бүрэлдэхүүнд гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, улаанзагалмай хорооны төлөөлөл (холбогч ажилтан)-ийг ажиллуулна.

2.5. Штабын бүрэлдэхүүн 08:30-17:30 цагийн хугацаанд үүрэг гүйцэтгэх бөгөөд шаардлагатай тохиолдолд ажлын хэсгийн ахлагчийн шийдвэрээр ажлын тусгай горимоор (уртасгасан цагаар) ажиллана.

2.6. Штаб нь гамшгаас хамгаалах өдөр тутмын бэлэн байдлын ногоон зэрэгт штабын даргын баталсан хуваарийн дагуу үүрэг гүйцэтгэж, өндөржүүлсэн бэлэн байдлын (шар) болон бүх нийтийн бэлэн байдлын (улаан) зэрэгт идэвхжинэ.

2.7 Өндөржүүлсэн бэлэн байдлын (шар) зэрэгт штабыг хэсэгчлэн идэвхжүүлнэ.

2.8 Бүх нийтийн бэлэн байдлын улаан зэрэг (улаан) зэрэгт штабыг бүрэн идэвхжүүлэх бөгөөд үүссэн гамшгийн нөхцөл байдал, цар хүрээнээс хамаарч өргөтгөн зохион байгуулж болно.

2.9 Штабын бүрэлдэхүүнд ажиллаж байгаа албан хаагчдын илүү цагаар ажилласан цагийн бүртгэлийг үндэслэн томилон ажиллуулсан байгууллага ажилтанд нэмэгдэл хөлс, шагнал, урамшуулал олгох асуудлыг шийдвэрлэнэ.

Гурав. Штабын эрх, үүрэг


3.1 Штаб дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

3.1.1 Улсын онцгой комисс, аймгийн онцгой комиссын шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих, гамшгаас хамгаалах алба, сумын Онцгой комиссын үйл ажиллагааг уялдуулах.

- 3.1.2 Гамшгийн аюулын бүх нийтийн болон хэсэгчилэн зарлан мэдээллийг дамжуулах.
- 3.1.3 Гамшиг, аюулт үзэгдэл, ослоос сэргийлэх, тэмцэх хариу арга хэмжээг төлөвлөх, зохион байгуулах;
- 3.1.4. Гамшгаас хамгаалах бүрэн болон хэсэгчилсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх цуцлах санал гаргах.
- 3.1.5. Нөхцөл байдалтай холбогдуулан хариу арга хэмжээнд төрийн цэргийн байгууллагыг татан оролцуулах саналыг гаргах,
- 3.1.6. Гамшгийн хор уршгийг арилгах ажиллагаанд гамшгаас хамгаалах улсын болон орон нутгийн алба мэргэжлийн ангийн хүч хэрэгслийг татан оролцуулах, хуваарилах,
- 3.1.7. Техник, тоног төхөөрөмж, багаж, хэрэгсэл, бараа материалын судалгааг гаргах, дайчлах, бүх төрлийн хангалтыг зохион байгуулах:
- 3.1.8. Сумын онцгой комисс, иргэд, олон нийтийг гамшиг, аюулт үзэгдэл, ослын нөхцөл байдал, хариу арга хэмжээний тухай мэдээ, мэдээллээр хангах;
- 3.1.9. Иргэдийн санал, хүсэлт, өргөдөл, гомдлыг хүлээн авах, шийдвэрлэх хариу өгөх арга хэмжээг зохион байгуулах хангах.
- 3.2. Штабын дарга дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:
- 3.2.1. Штабын үйл ажиллагааг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангах
- 3.2.2. Штабын бүрэлдэхүүн, гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, орон нутгийн шуурхай штабуудад үүрэг, чиглэл өгөх, биелэлтийг хангуулах, хяналт тавих
- 3.2.3. Үүссэн нөхцөл байдалтай холбогдуулан авч хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг аймгийн Онцгой комисст танилцуулах
- 3.2.4 Гамшгийн голомтод томилгоот хүч хэрэгслийг ажиллуулах, тэдгээрийг удирдлагаар хангах, байгууллага хоорондын харилцан ажиллагааг зохицуулах, удирдлагыг мэдээллээр хангах, хангалтыг зохион байгуулах болон хяналт шалгалт хийх зорилгоор удирдлагын шуурхай бүлэг томилон ажиллуулах;
- 3.2.5 Сумын онцгой комиссыг мэдээллээр хангах;
- 3.2.6. Бусад.
- 3.3. Штабын орлогч дарга дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:
- 3.3.1. Багуудын үүрэг гүйцэтгэлтэд хяналт тавих штабын даргын өгсөн үүргийн хэрэгжилтийг зохион байгуулах;
- 3.3.2 Үүссэн нөхцөл байдалтай холбогдуулан авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал шийдвэрлэх асуудлыг штабын даргад танилцуулах.
- 3.3.3 Багуудын үйл ажиллагааны төлөвлөгөө тайланг хянах авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар штабын даргыг мэдээллээр хангах.

3.3.4. Штабын бүрэлдэхүүний ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, ажил, амралтын цагийг зохицуулах, эрүүл мэндийг хамгаалах;

3.3.5. Бусад



—oOo—